



МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

Хуульд заасан шаардлага: Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн, эдгээр салбарын ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн, дараахь шаардлагыг хангасан хүн байна:

1/ Монгол Улсын 30-аас дээш насны иргэн, ял шийтгэлгүй;

2/ банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн мэргэжлээр магистрын болон түүнээс дээш зэрэг, цолтой.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:

5.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр банк, санхүү, эдийн засгийн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллагад өмнө нь ажиллаж байсан хүнийг томилж болно.

6.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн бусад албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, төрийн захиргааны албан тушаалтан, Монголбанкны удирдах албан тушаалтныг томилж үл болно.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<p>Эцэг/эхийн нэр: Тунсаг Ургийн овог: Даваа Нэр: Тэлмэн Хүйс: Эрэгтэй Төрсөн он: 1978 оны 8 дугаар сарын 25 Төрсөн газар: Прага хот, БНЧУ Иргэний харьяалал: Монгол улс Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 34-р байрны 26 тоот <i>/мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/</i></p>
1.2	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</p> <p>Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүн</p>
1.3	<p>Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/</i></p> <p>Тийм</p>
1.4	<p>Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. <i>/сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/</i></p> <p>2007-2009 онд Миссури мужийн их сургууль, Спрингфильд хот АНУ, Бизнесийн удирдлагын магистр 2003-2004 онд Гадаад худалдааны академи, Рейтлинген хот Баден-Вуртэнберг муж, ХБНГУ, Мэргэжил дээшлүүлэх сургалт 1996-2000 онд Санхүү эдийн засгийн дээд сургууль, Банк санхүүгийн тэнхим, Санхүүч, банкны эдийн засагч, Бизнесийн удирдлагын бакалавр</p>
1.5	<p>Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг</p> <p>Байхгүй.</p>
1.6	<p>Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана.</p> <p>Байхгүй.</p>

1.7

Эрхэлсэн ажил

Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг, банк, санхүү, эрх зүйн аль нэг чиглэлээр эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана.

Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.

2019 – одоог хүртэл Бизнес эрхэлсэн дэд захирал, Амар Даатгал ХХК, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Блю ский товер 20 давхарт, www.amardaatgal.mn 1800-2111

2018 – 2021 онд Төслийн зөвлөх, “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн эрх зүйн орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл” Азийн Хөгжлийн Банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж, www.adb.org 11-329836

2016 – 2017 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын зөвлөх, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам, Улаанбаатар, Чингэлтэй дүүргийн 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160 www.mlsp.mn 11-328634

2016 – 2020 онд Мэргэжлийн зөвлөлийн гишүүн, Санхүүгийн Удирдлагын Тэнхим, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, БЗД 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-5, 13381, Ш/Н: Улаанбаатар-49, info@ufe.edu.mn 7735-0000

2014 – 2016 онд Гүйцэтгэх захирал, Микрокредит ББСБ ХХК, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Чинван Ханддоржын гудамж, 52-р байр, www.microcredit.mn 7000-0979

2013 – 2014 онд Хөрөнгө оруулалт, эдийн засгийн газрын захирал, Монголын Алт Корпораци, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар хот, 17030, Ш/Х-66 www.mak.mn 7575-9707

2010 – 2013 онд Даатгал эрхэлсэн дэд захирал, Монгол Даатгал ХХК, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, Хуучнаар Тээврийн товчооны ард, www.mongoldaatgal.mn 1800-1990

2010.II-VIII сард Хянан шалгагч, Улсын байцаагч, Хяналт шалгалтын газар, Монголбанк, Бага тойруу-3, 15160, Улаанбаатар-46, Монгол Улс, www.mongolbank.mn 11-310081

2004 – 2007 онд Аудитор, Улсын байцаагч, Дотоод хяналтын газар, Монголбанк

2004.III-XI сард Дадлагажигч, туслах ажилтан, Хөрөнгө оруулалт, санхүүгийн алба, Дойче Банк ХК, Иргэдийн болон байгууллагын харилцагчийн газар, Берлин хот, ХБНГУ, www.db.com

2000 – 2003 онд Аудитор, Дотоод хяналтын газар, Монголбанк (Төв банк)

1.8	<p>Ашиг сонирхлын зөрчил Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар хувьцаа, аж ахуйн үйл ажиллагааг ямар хугацаанд эзэмшиж, эрхэлж байгаа, эсхүл эзэмшиж, эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p> <p>Микрокредит ББСБ ХХК-ийн энгийн хувьцааны 46.2 хувийг эзэмшдэг Амар Даатгал ХХК-ийн энгийн хувьцааны 4.7 хувийг эзэмшдэг</p>
1.9	<p>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i></p> <p>Үгүй</p>
1.10	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p> <p>Үгүй</p>
1.11	<p>Мэргэжлийн ёс зүйн талаар Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх. <i>/тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i></p> <p>Үгүй</p>

1.12 Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол

-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.

-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

2016-2017 онд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн ажлын хэсгийн гишүүн, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Хуулийн ажлын хэсгийн гишүүнээр ажилласан.

2016-2017 онд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн ажлын хэсгийн ахлагч, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, 2018-2021 онд АХБ-ны төслийн дотоодын зөвлөхөөр ажиллан, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг ХНХ яаманд хүлээлгэн өгсөн.

2021-2022 онд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн ажлын хэсгийн гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ажлын хэсгийн гишүүнээр ажилласан.

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

/Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>/500-1000 үгэнд багтаана/.</i></p> <p>Тунсаг овогтой Тэлмэн миний бие 2000 онд Санхүү, эдийн засгийн дээд сургуулийг санхүүч, банкны эдийн засагч мэргэжлээр бакалаврийн, 2009 онд АНУ-ын Миссури мужийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрийн зэрэгтэй төгссөн бөгөөд ажиллаж байх хугацаандаа 2001 онд ХБНГУ-ын Дойче Бундесбанк (Төв банк)-нд дотоод аудитын чиглэлээр, 2003-2004 онд тус улсын Гадаад худалдааны академид маркетингийн удирдлагын чиглэлээр, 2024 онд Япон улсын Даатгалын ерөнхий сургуулийг арилжааны даатгалын удирдлагын чиглэлээр тус тус мэргэжил дээшлүүлсэн.</p> <p>Миний бие өнгөрсөн 24 жилийн хугацаанд ажиллахдаа Төв банкны хяналт шалгалт, дотоод аудит, нийгмийн болон арилжааны даатгал, эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалтын чиглэлээр голчлон ажиллаж, өнгөрсөн 14 жилд тодорхой түвшний удирдах албан тушаал хашсан байна. Иймд өөрийн ажлын туршлага, өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан мэдлэг боловсролдоо тулгуурлан Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүнээр ажиллах хүсэлтээ гаргаж байна.</p> <p>Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүнээр томилогдон ажилласан нөхцөлд миний бие дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд болон Монголбанкны хяналтын зөвлөлийн ажиллах журмын хүрээнд ажиллана.- Монголбанкны санхүүгийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлэх, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д хэрхэн нийцэж байгаа болон шаардлагатай ямар ажлууд хийгдэж буй тал дээр хяналт тавьж ажиллана.- Олон улсын зэрэглэл өндөртэй аудитын байгууллагыг сонгон шалгаруулах, хамтран ажиллах тал дээр анхаарахаас гадна өнгөрсөн хугацаанд аудитын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтийн хангуулах тал дээр анхаарна.- Монголбанкны удирдлагын хороо (Зөвлөл)-ны тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянах, үр дүнг тооцох, Монголбанкны хяналтын зөвлөлөөс санал зөвлөмж өгч ажиллана.- Төв банкны эрсдэлийн удирдлагын зөв зохистой тогтолцоо бүрдсэн эсэхэд анхаарах, эрсдэлийн удирдлагын албаны болон дотоод аудитын газрын чиг үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбоог хэрхэн хангаж буй байдал болон олон улсын стандарт, жишигт нийцсэн эсэхэд анхаарна.- Монголбанкны дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэх, гадны мэргэжлийн зөвлөх, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, туршлага солилцох, тус газрын удирдлага, ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшүүлэх тал дээр анхаарч ажиллана.- Монголбанкны хөрөнгө оруулалтын багцын шинжилгээ боловсруулалт, нөөцийн удирдлагын бодлого, дүрэм журам, түүний хэрэгжилт, зөв
-----	--

	<p>зохистой эрсдэлийн удирдлагын тогтолцоо байгаа эсэх болон тайлагналын байдал хяналт тавьж, онцгой анхаарж ажиллана.</p> <ul style="list-style-type: none">- Монголбанкны удирдлагын хороо болон удирдлагаас хараат бус, бие даасан зарчмыг баримтлан ажиллах болно.
--	--

Хавсралт:

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:

- 1.Төрийн албан хаагчийн анкет;
- 2.Эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр;
- 3.Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- 5.Боловсролын зэргийн дипломын хуулбар;
- 6.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
- 7.Төв банк/Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан чиглэлээр мэргэшсэн, тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт;
- 8.Энэхүү загварт заасан баримт бичиг;
- 9.Холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Тунсаг

Өөрийн нэр: Тэлмэн

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2024 оны 12 дугаар сарын 19